

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар А/24

Арвайхээр

Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг
“Комирнэти” (BNT162B2) вакцинаар дархлаажуулах тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн “Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг “Комирнэти” (BNT162b2) вакцины нэмэлт тунгаар дархлаажуулах тухай” А/314 дүгээр тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Пфайзер -БиоН”Тех үйлдвэрийн “Комирнэти” (BNT162b2) вакцинаар зааврын дагуу сайн дурын үндсэн дээр эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрлийг үндэслэн 12-17 насны хүүхдийг 2 дугаар тунг хийлгэснээс хойш 5 сарын дараа нэмэлт тунгаар вакцинжуулах арга хэмжээг 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.
2. Зорилтот насны хүүхдийг вакцинжуулах арга хэмжээг зохион байгуулах, мэргэжлийн удирдлаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтэс (М.Золзаяа), хүүхдийн эцэг эх, асран хамгаалагчаас урьдчилан зөвшөөрөл авч вакцинжуулах, дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийг бүртгэх, мэдээлэх, тандах журмын хэрэгжилтийг чанд мөрдөн ажиллахыг Хархорин сумын нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт тус тус даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтэс (Я.Жаргал)-д даалгасугай.

ДАРГА



Д.ШИВААННҮРДЭВ

189000051

My Doc.tushaal/EMG/